

ХБНГУ-ЫН МУЖ УЛСУУД, МОНГОЛ УЛСЫН ХООРОНДЫН ХАРИЛЦАА

Монгол-Германы ард түмнүүдийн хоорондын харилцаа, харилцан бие биенээ мэдэх болсон явдлыг түүхийн үүднээс хөөж үзвэл хэдэн зууны тэртээ хамаарагдах бөлгөө. Энэхүү харилцааны олон зуун жилийн уламжлалтай, харилцан бие бие рүүгээ тэмүүлэх шинж онцлог ямагт байсан авч цаг үеийн түүхийн бэрхшээл, нугачаанаас улбаалж нэг үе идэвхжиж, нэг үе тасалдаж байсан түүхтэй.

Өнөө үед Монгол-Германы харилцаа улс төр, эдийн засаг, соёл боловсрол, шинжлэх ухаан хүмүүнлэгийн бүх салбарт идэвхжин эрчимтэй хөгжиж байна. Холбооны бүтэцтэй Герман Улсын хувьд Төв Засгийн газартай төдийгүй харьцангуй бие даасан, тодорхой мэдэл бүхий Холбооны муж улсуудтай нь хамтын ажиллагаа хөгжүүлэх нь чухал ач холбогдолтой юм. ХБНГУ нь 16 муж улсуудаас бүрэлддэг бөгөөд эдгээр муж улсууд нь эдийн засаг, санхүүгийн хувьд ихээхэн бие даасан байдалтай байдаг ба одоогийн энэ бүтэц нь дайны дараа 1945 оноос хойш газар нутаг, уламжлалын онцлог байдал, эдийн засаг, аж ахуйн харилцааны нийтлэг байдлыг харгалзан зохион байгуулагдсан байна.

Дэлхийн II дайн дууссаны дараа Германы газар нутаг дээр герман үндэстний хоёр улс (баруун, зүүн) бий болсон юм. Гэвч 1990 онд герман үндэстний хоёр улс нэгдснээр ХБНГУ-ын муж улсын бүрэлдэхүүнд өөрчлөлт орж Бранденбург, Мекленбург-Помфоммерн, Саксон, Тюринген муж улсууд нэмэгдэн орсон ба зүүн Берлин ч баруун Берлинтэйгээ нэгдсэн юм. Ийнхүү өнөөгийн Германы 16 муж улсууд бий болсон түүхтэй.

Германы одоогийн муж улсуудын газар нутаг, хүн ам, засаг захиргааны ангилал

| Муж улсын нэр | Газар нутгийн хэмжээ кв.км-ээр (31.12.2003 байдлаар) | Газар нутгийн хэмжээ %-иар (31.12.2003 байдлаар) | Нийт оршин суугчид (31.12.2004 байдлаар) | 2003/2004 оны оршин суугчдын зөрүү |
|-----------------------|--|--|--|------------------------------------|
| Баден-Вюрттемберг | 35 751,65 | 10,01 | 10 717 419 | 24 863 |
| Бавари | 70 549,19 | 19,76 | 12 443 893 | 20 507 |
| Берлин | 891,75 | 0,25 | 3 387 828 | -649 |
| Бранденбург | 29 477,16 | 8,26 | 2 567 704 | -6 817 |
| Бремен | 404,23 | 0,11 | 663 213 | 84 |
| Хамбург | 755,16 | 0,21 | 1 734 830 | 747 |
| Хессен | 21 114,72 | 5,91 | 6 097 765 | 8 337 |
| Мекленбург-Порфоммерн | 23 174,17 | 6,49 | 1 719 653 | -12 573 |
| Нийдерсаксон | 47 618,24 | 13,34 | 8 000 909 | 7 494 |
| Нордрайн-Вестфален | 34 089,52 | 9,55 | 18 075 352 | -4 334 |
| Райнланд-Пфальз | 19 847,37 | 5,56 | 4 061 105 | 2 423 |
| Заарланд | 2 568,65 | 0,72 | 1 056 417 | -4 959 |
| Саксон | 18 413,91 | 5,16 | 4 296 284 | -25 153 |
| Саксон-Анхальт | 20 445,26 | 5,73 | 2 494 437 | -28 3504 |
| Шлесвиг-Хольштайн | 15 763,18 | 4,42 | 2 828 760 | 5 589 |
| Тюринген | 16 172,14 | 4,53 | 2 355 280 | -17 877 |
| ХБНГУ | 357 030,32 | 100,0 | 82 182 824 | -30 822 |

Сурвалжийн үрэлжлэл

| Муж улсын нэр | Нэг кв.км-т ноогдох оршин суугчдын тоо (31.12.2003 байдлаар) | Оршин суугчдын тоо %-иар (31.12.2004 байдлаар | Гадаад иргэд нийт (31.12.2004 байдлаар | Холбооны нийт нутагт гадаадын иргэдийн эзлэх хувь (31.12.2004 байдлаар) |
|-----------------------|--|---|--|---|
| Баден-Вюрттемберг | 299 | 12,99 | 1 281 717 | 12,0 |
| Бавари | 176 | 15,08 | 1 175 198 | 9,4 |
| Берлин | 3800 | 4,11 | 454 545 | 13,4 |
| Бранденбург | 87 | 3,11 | 67 222 | 2,6 |
| Бремен | 1640 | 0,80 | 86 650 | 13,1 |
| Хамбург | 2296 | 2,10 | 244 401 | 14,1 |
| Хессен | 288 | 7,39 | 694 693 | 11,4 |
| Мекленбург-Порфоммерн | 75 | 2,08 | 39 417 | 2,3 |
| Нийдерсаксон | 168 | 9,70 | 536 939 | 6,7 |
| Нордрайн-Вестфален | 530 | 21,91 | 1 944 556 | 10,8 |
| Райнланд-Пфальц | 204 | 4,92 | 311 556 | 7,7 |
| Зaarланд | 413 | 1,28 | 88 925 | 8,4 |
| Саксон | 235 | 5,21 | 118 480 | 2,8 |
| Саксон-Анхальт | 123 | 3,02 | 47 123 | 1,9 |
| Шлесвиг-Хольштайн | 179 | 3,43 | 151 286 | 5,3 |
| Тюринген | 147 | 2,85 | 47 817 | 2,0 |
| ХБНГУ | 231 | 100,0 | 7 289 979 | 8,8 |

Эх сурвалж: Холбооны Статистикийн Алба 2005 он

Холбооны муж улсуудыг эдийн засгийн хүчин чадлын хувьд харьцуулах нь /2003 он/

| Муж улсын нэр | Ажилгүй- чүүдийн квот 2003 оны дундаж (%-иар) | Дотоодын Нийт Бүтээгдэхүүн /ДНБ/ (тухайн үеийн ханшаар) | | | |
|-----------------------|--|--|---|---|---|
| | | 2003 он | | | |
| | | Нийт (млрд евро- гоор) | Бодит өөрчлөлт 2002 онтой харьц. (%-иар) | Холбоо- ны ДНБ-д эзлэх хувь | Хөдөлмөр эрхлэгч- дэд ногдох евро |
| Баден-Вюртемберг | 6,2 | 312,3 | +1,0 | 14,7 | 58 497 |
| Бавари | 6,9 | 375,9 | +1,2 | 17,7 | 60 625 |
| Берлин | 18,1 | 76,8 | -0,2 | 3,6 | 50 740 |
| Бранденбург | 18,8 | 44,3 | +0,7 | 2,1 | 43 648 |
| Бремен | 13,2 | 23,2 | +0,3 | 1,1 | 59 465 |
| Хамбург | 9,9 | 76,7 | +1,2 | 3,6 | 74 502 |
| Хессен | 7,9 | 190,1 | +0,7 | 8,9 | 63 707 |
| Мекленбург-Порфоммерн | 20,1 | 29,3 | +0,0 | 1,4 | 41 220 |
| Нийдерсаксон | 9,6 | 181,9 | +1,4 | 8,5 | 52 302 |
| Нордрайн-Вестфален | 10,0 | 469,7 | +0,7 | 22,1 | 56 998 |
| Райнланд-Пфальз | 7,7 | 93,2 | +1,3 | 4,4 | 53 461 |
| Заарланд | 9,5 | 25,3 | -0,3 | 1,2 | 50 675 |
| Саксон | 17,9 | 77,9 | +2,2 | 3,7 | 40 629 |
| Саксон-Анхальт | 20,5 | 44,9 | +1,7 | 2,1 | 44 402 |
| Шлесвиг-Хольштайн | 9,7 | 65,1 | +0,8 | 3,1 | 53 771 |
| Тюринген | 16,7 | 41,5 | +1,6 | 1,9 | 40 309 |
| ХБНГУ | 10,5 | 2128,2 | +1,0 | 100,0 | 55 546 |

Эх сурвалж: Холбооны Хөдөлмөр эрхлэлтийн агентлаг 2005.

Муж улсуудын макро эдийн засгийн ерөнхий тооцоог гаргах ажлын хүрээнд 2005 оны хавар хийж гүйцэтгэсэн байна.

Германы муж улсуудаас Бавари нь эдийн засаг, соёл боловсрол, шинжлэх ухааны хувьд эрт дээр үеэс уламжлалтай гол орон юм.

Бавари муж улс¹

| | |
|-------------------|------------------------|
| Хүн: | 12, 330 сая |
| Газар нутаг: | 70 549 км ² |
| Хүн амын нягтрал: | 173 |
| Нийслэл: | Мюнхен |

Бавари нь хаант засаглалгүй Бүгд Найрамдах Улс гэсэн утгатай "Чөлөөт улс" /Freistaat гэдэг түүхэн нэр юм. Баварийн оршин суугчид VI зуунаас эхтэй өөрийн муж улсын түүхээр бахархдаг.

Бавари муж улс өөрийн түүх, соёлын өв хийгээд байгалын үзэсгэлэнт газруудаараа жуулчдын сэтгэлийг ихээхэн татдаг байна. Альпийн уулс, өмнөд Альпийн өндөрлөгт орших үлгэрийн мэт нуурууд, Баварийн ойд орших үндэсний хүрээлэн, Франкын Альб, Фихтельгебирге, Штайгервальд, Шпессарт болон бусад амралтын газрууд байгалын үзэсгэлэнгээрээ онцгой сэтгэгдэл үлдээнэ.

Бавари нь хөдөө аж ахуйгаас орчин үеийн аж үйлдвэрийн өндөр хөгжилтэй орон болон хувирсан бөгөөд ирээдүйд шинжлэх ухаан, эдийн засаг, техникийн тэргүүлэх хэмжээний ихээхэн чадавхитай улс юм.

Баварид "Сименс", "БМВ", "Ауди", "Даса-аэропейс" болон МАН зэрэг алдартай үйлдвэрүүд байдаг ба өнөөгийн байдлаар мэдээллийн хэрэгслийн хувьд ч тэргүүлэх төв байсаар байна. Одоогоор дотоодын нийт бүтээгдэхүүний 35 орчим хувь нь хөдөө аж ахуйн салбарт, 50 гаруй хувь нь аж үйлдвэрийн салбарт ноогдож байна.

¹ *Германия Факты*, Федеральное Министерство Иностранных дел, Берлин 2003, стр. 26-27.

Баваримужулшинжлэх ухаан, судалгаа, мэдээллийн тогтолцоогоо эрхэмлэдэг орон бөгөөд 26 Их сургууль, нарийн мэргэжлийн дээд сургууль, шинжлэх ухаан, судалгааны 3 томоохон цогцолбор, Макс Планкын нэрэмжит 11 институт, Фраунгоферагийн нэрэмжит Нийгэмлэгийн 7 байгууллагатай.

Бавари муж улс өөрийн соёлын өвийг хамгаалахад зориулж жил тутам 50 гаруй сая еврог зарцуулдаг бөгөөд түүний агуулга нь олон тооны музейг хөгжүүлэх, 33 театрт орчин үеийн Панакотека-г нэмэгдүүлэх, 34 задгай театрт, түүнчлэн Байротын нэрэмжит олон улсын фестиваль болон 10 жил тутам болж өнгөрдөг "Обераммергауэр пассионспиль" фестивалиуд болно.

Нийслэл Мюнхен хот (1 260 597 оршин суугчидтай) нь янз бүрийн соёл, гэгээрлийн хүрээллийг санал болгох ба олон төрлийн архитектуртай хөшөө дурсгал, дэлхий дээрх үндэсний баяруудаас хамгийн томд тооцогдох "Октоберфест зэрэг нь анхаарал татна.

Мюнхентэй адил алдартай хотууд нь Нюренберг (488 400 оршин суугчидтай), Таубер дэхь Ротенбург (12 000 оршин суугчидтай) хотууд юм. Эдгээр хотууд нь эртний Франкын Эзэнт улсын үеийн хотууд бөгөөд Гучин жилийн дайнаас хойш өнөөг хүртэл төдий л өөрчлөгдөлгүй үлджээ. Эртний Эпископ (Хамбатны)-ын хот Вырцбург (127 166 оршин суугчидтай) өөрийн зуушны газруудаараа жуулчдыг тааад зогсохгүй Франкын дарс үйлдвэрлэл, худалдааны төв юм.

Бамберг (69 430 оршин суугчидтай) хот бол эртний Франкын хот бөгөөд урьдын Эзэнт улсын хийгээд Хамба ламтны орд өргөө бүхий алдартай түүхийн төв болно. Регенсбург (125 676 оршин суугчидтай) хот мөн энэ жагсаалтад зүй ёсоор багтана. Байрот хот (73 661 оршин суугчидтай)-ын фестивальд Рихард Вагнерын хөгжмүүдийг "Ногоон толгод" хэмээх дуурын театрт тоглодог байна.

Германы муж улс, аж ахуйн байгууллагуудын харилцаа, хамтын ажиллагаа нь Монгол-Германы эдийн засгийн хамтын ажиллагааны чухал хэсэг болж байна. ХБНГУ-ын баруун нутгийн

эдийн засгийн нөөц, потенциал бүхий санхүү, эдийн засаг, аж үйлдвэрийн голлох муж улсын нэг болох Бавари муж улстай манай улс "Соёл, боловсрол, шинжлэх ухааны салбарт хамтран ажиллах тухай протокол" /1995/, "Хамтын ажиллагааны тухай хамтарсан мэдэгдэл" /1997/-д гарын үсэг зурсан юм. Баваритай соёл, боловсрол, шинжлэх ухааны хамтын ажиллагааны зөвлөл байгуулагдан ажиллаж байна. Мөн манай улсын МУИС, ШУТИС, ХААИС зэрэг их, дээд сургуулиуд Бавари муж улстай өргөн харилцааг хөгжүүлж болж байна.

Жишээ нь, Монгол Улс болон ХБНГУ-ын Бавари мужийн хамтын ажиллагааны гэрээний дагуу 1996 оны 5-р сард ХААИС-ийн 3 багш Вайнштепаны мэргэжлийн Их сургуульд айлчилж, тус сургуулийн үйл ажиллагаатай танилцан профессор багш нартай Монголын ХААИС-д жимс-ногооны сургалтыг хөгжүүлэх талаар хамтран ажиллахаар тохиролцсон байна. 1996 оны 8-р сард профессор Ф. Френц, Х. Хельм нар Монголд зочилж ХААИС, Дарханы УГТСЭШХ, Шаамар, Мандалговь зэрэг газруудаар аялж, Монгол орны байгаль цаг уурын нөхцөлтэй танилцаад буцсан бөгөөд 1997 оны 2-р сард ХААИС дээр "Жимс-ногооны сургалт" симпозиум зохион байгуулж, багш, эрдэм шинжилгээний ажилтан, оюутнууд, зарим газар тариалангийн компаниуд, хувиараа хүнсний ногоо тариалдаг хот, хөдөөгийн 100-аад хүн оролцсон байна. Мөн профессор Ф. Френц 2000 оноос гэргий Элизабетийн хамт тус сургууль дээр 4-5 сарын хугацаатай ажиллаж, багш, оюутнуудыг сургах дадлагажуулах сургалт, жимс-хүнсний маркетингийн семинар зохион ХБНГУ-ын хөрөнгө оруулалттай зарим байгууллагуудтай түншийн харилцаа тогтоосон ба усалгааны лаборатори, сургалтад зориулсан хүлэмж, дуслын усалгааны групп байгуулах зэрэг ажлуудыг хийжээ. Энэ хугацаанд герман хэлний сургалтыг зохион байгуулж, нийт 80 багш, оюутан хамрагдаж хэлний мэдлэгээ дээшлүүлсэн байна.

ХААИС-ийн багш, оюутнуудаас жил бүр Вайнштепаны мэргэжлийн Их сургуульд үйлдвэрлэлийн дадлага хийж, магистрантурт сурч мэргэжил дээшлүүлж байгаа бөгөөд энэ чиглэлээр явж суралцсан багш 10, оюутан 22 байна. Түүнчлэн ХБНГУ-аас ХААИС-ийн номын санд мэргэжлийн ном, сурах бичгийн баяжуулалт хийсэн байна.

Мөн Баден-Вюртемберг муж улстай аялал жуучлал, Нордрайн Вестфален муж улстай парламент, соёл боловсролын салбарт, Бранденбург муж улстай байгаль хамгаалах салбарт, харилцаа, хамтын ажиллагаа явагдаж байна. Хессен муж улстай хамтын ажиллагааны эхлэл тавигдан газрын кадастрын албыг бэхжүүлэх төслийг буцалтгүй тусламжийн журмаар хэрэгжүүлэхээршийдвэрлэж ажлаа эхлэх гэж байна. Эдийн засаг, соёл, боловсрол, шинжлэх ухааны хамтын ажиллагаа эхлэлтийн байдалд байна. Райнланд Пфальз муж улстай хамтын ажиллагааны эхлэл тавих ажил хийгдэж байна. ХБНГУ-ын бараг бүх муж улсуудад манай иргэд суралцаж, зарим иргэд ажиллаж амьдарч байгаа болно.

Дархан хот 1988 оноос Германы Цайц хоттой, Төв аймгийн Бүрэн сум Германы Бүрэн хоттой 1994 оноос түншийн харилцаатай ажиллаж байна. 1997 оноос Монгол Улс ХБНГУ-ын Бавари муж улстай шууд хамтын ажиллагаа тогтоов. 1999 онд ч орон нутгийн засаг захиргааны нэгжүүдийн шууд түншлэлийн чиглэлээр ахиц гарав. Тухайлбал, Улаанбаатар Бонн хотууд, Архангай аймаг Германы Добэрлүг-Кирххайн хотын хооронд хамтын ажиллагааны эхлэл тавигдаж, Улаанбаатар хотын Баянгол дүүрэг Берлин хотын Шёнефельд дүүрэг хоорондын харилцаа идэвхтэй хөгжиж байна. Түүнчлэн, манай улстай холбоо харилцаа санаачлан тогтоож гүнзгийрүүлж буй Бавари муж улсын Майзах сум, Нийдэрсаксон муж улсын Фэрдэн хот, Саксон муж улсын Миттвайда хот (Хөвсгөл аймагтай) зэрэг газрууд байна. 2002 онд ХБНГУ-ын Хессен муж улстй харилцаа, хамтын ажиллагааны талаарх хамтарсан мэдэгдэл байгуулснаар муж улсуудтай байгуулсан харилцаа өргөжиж байна.